

**"Ch'ophae mong-ö"-ийн монгол бичвэр дэх
манж хэлний нөлөө**

М.Баярсайхан (МУИС)

Сурвалжийн мэдээг үндэслэн 14-18-р зууны үед Солонгост монгол хэлний сургалт ба орчуулгад зориулсан зохиол наанадаж 24 гарсныг судлаачид бүртгэжээ. [Son Ki-Joong, 2001. 84-126p] Тэдгээрээс эдүгээ уламжлан ирсэн 7 зүйлийн бичиг буйгаас чухам монгол хэлний сургалтад гол хэрэглэж ирсэн нь Mongö pogöltae, Ch'ophae Mongö, Mongö yuhae хэмээх 3 бичиг бөгөөд бусад нь дөрөв, таван хэлний толь, монгол арван хоёр толгой үсэг зэрэг зүйл аж.

18-р зууны үеэс солонгост "Монгол хэлний гурван сурах бичиг" хэмээн алдаршсан дээрх нэр бүхий бүтээлүүд нь тухайн үеийн монгол хэл аялгууны онцлогийг тусгасан төдийгүй солонгос, монгол соёлын харилцаанд холбогдох онцгой дурсгал юм.

Солонгос хүнд зориулсан монгол хэлний сурах бичгүүдтэй холбогдох судалгааны хэд хэдэн бүтээл гарсны дотор, эрдэмтэн Lee Seong Gyu тухайлан дээрх гурван бичгийн монгол хэлний онцлогийг сонгодог монгол бичгийн хэлний тогтсон хэм хэмжээтэй харьцуулж нарийвчлан судалжээ. Тэр бээр мөн сурах бичгүүдэд солонгос хэлний нөлөө бүхий монгол хэлний зүй ёсноос гажиж өөрдсөн зүйлүүд байгааг ч тодорхой дурдсан билээ. Ийнхүү аливаа дурсгал дахь монгол хэл аялгууны онцлог ба өөр хэлний нөлөөг ялган таньж тодруулах нь эх бичгийн судалгааны чухал асуудал болно.

Тус өгүүлэлд "Ch'ophae mongö" хэмээх сурах бичгийн эдүгээ Сөүлийн Их Сургуульд хадгалж буй 1790 оны буюу 2 дахь барламал эхийн хуулбар хэвлэлийг нягтлан түүний монгол бичвэрийн найруулгад, нөгөөтэйгүүр манж хэлний нөлөө тусгал гэж үзмээр зарим онцлог буй талаар өгүүлсү. Дашрамд өгүүлэхэд монгол, япон хэлний "Ch'ophae" бичиг тус тус уламжилсан бөгөөд зөрчин, манж, хятад хэлний "Ch'ophae" бичиг байсан эсэх тухай мэдээ хараахан олдоогүй ажээ.

Нөхцөлийн хэрэглээ, найруулга өөрдсөн нь

Манж хэлний нэр ба үйлийн нөхцөл нь хэлзүйн ай тус бүрт монгол хэлнийхээс тооны хувьд харьцангуй цөөн байдаг. Иймд нөхцөлийн олон утга, найруулгын өнгө аяст нийцүүлэх зэрэг шаардлагын улмаас манж хэлний нэгэн нөхцөлийг тухай тухайн орчин, хам сэдвээс нь хамааран монгол хэлний хэд хэдэн нөхцөлөөр буулгаж орчуулдаг. Гэвч манжижсан монгол хэлний найруулга болон зарим ядмаг орчуулгын зүйлд нөхцөлийн гол утгад дүйх хэлбэрийг нь хэт барин тохиолыг ялгалгүй онолдуулсан үзэгддэг. Манж хэлний нөхцөлийг оновчгүй орчуулсан эсвэл манжижсан найруулга гэж үзмээр өгүүлбэр "Ch'orphae mongdö"-д хэдэн зүйлээр тохиолдож байна.

1. "Манж хэлний өгөх-оршихын тийн ялгалын нөхцөл - **de** нь *olxo-* (болгоомжло-), *sengguwe-* (эмээ-), *gele-* (ай-), *jaila-* (зайла-), *jobo-* (зово-), *fonji-* (асуу-), *giru-* (ичи-), *donji-* (сонос-), *ta ā-* (сур-) гэсэн үгсийн өмнөх нэр хийгээд зарим нэг оноосон нэр лүгээ нөхцөлөө гарахын тийн ялгалын нөхцөлийн утгатай болдог" (Го.Мижиддорж. 1976. 75-р тал). Уг зохиолын

ülü itegebesü eden dūr asaγun üje. (2.19b)

bi mön tegün dūr ayuqu uu (3.6b)

Baysi dur ayuqu ügey bolbasu basa ken dūr ayumuy aji (3.6b)

Kedü ügey bolbaču mön nököd tür aγsun abuju öber-tür neyilegülün öggümüy (2-12b)

Bi mönü āmadur bānen üge asaγuγsan anu... (3.8a) зэрэг өгүүлбэр дэх *dur*², *tur*² нөхцөл нь цөм гарахын тийн ялгалын утгаар хэрэглэгдсэн манж хэлний - **de** нөхцөлийн үгчилсэн орчуулга мэт болжээ.

2. Манж хэлний заахын тийн ялгалын - **be** нөхцөл нь үндсэн утгаасаа гадна үйлдэх, хамтрахын тийн ялгалын утгыг илтгэдэг.

ā jam-dur tere kümün-i jolyaγsan biliü (3.7a)

γayča ene kümün-i učaraba (3.7a-b)

Enedür jabsiyan-iyar basa abayay-yi jolyaba (4.13b-19a)

Эдгээр жишээг үзвэл, хамтрахын тийн ялгалтай дүйх газарт манж хэлний - **be**-г мөн л үндсэн утгын буюу толь бичигт тусгагдсан *i*, *yi* хэлбэрээр нь буулгасан мэт байна.

3. *Qadaγalaju tan-u gerte aγurqan-iyar beyen-ü idesügey geneü* (3.10b)

"*beyen-u idesügey*" гэдэг үг манж хэлний "*beyei jeki*" гэдэг үгийн орчуулга болов уу. Манжийн -*i* нөхцөлийн гол утга нь харьяа хамаа заахаас гадна үйлдэхийн тийн ялгалын утга илтгэдэг. Үүнийг буруу орчуулснаас "*beye-ber idesügey*" гэх газар "*beyen-ü idesügey*" гэж бичжээ.

4. *Toli-yi üyiledün sayiqan masi ariγun tunqalaya* (1-8a) манж хэлний нөхцөлдүүлэн холбох - **me** нөхцөлийг монгол хэлний 1. хамын -*n*, 2. зэрэгцэх - *ju*², - *ā*², 3. бэлтгэх - *ma*; *ča*², 4. зорих - *r-a*², 5. эшлэх - *run*² зэрэг нөхцөлөөр орчуулдаг. Энэ өгүүлбэрт манж хэлний *weileme* гэдэг үгийг *üyiledumegče* хэмээн орчуулах байтал *üyiledün* гэж буулгасан бололтой.

5. Уг сурах бичигт ирээдүй цагаар тодотгон холбох - *qu*, - *kü* нөхцөлөөр өгүүлбэр төгсгөсөн жишээ 12 байна.

γayca alyur aγajim-iyar kelelcöged demey bitegey γayaraqū (1.6a)
öberen daγabasu ä mön bitegey bayarlaqu. öberen daγaqu ügey bolbasu abaγay mön bitegey γasalaqu. (2.9b-10a)
ene kereg ügey ügen-i jīä bitegey ögülekü (2.17a)
busud γajar-tur bitegey odqu. (3.9b)
ä tegün-ü qaγurqu ügen-i bitegey iteqekü. (4.8a) гм.

Манж хэлний - *ra*, - *re*, - *ro* хэлбэр өгүүлбэрийн дунд монгол хэлний үйлийн тодотгон холбох - *qu*, - *kü* нөхцөлтэй дүйж, өгүүлбэрийн адагт орвол - *γun*, - *gtün* нөхцөлтэй тохирдог. Ийнхүү II биед хүндэтгэн захирсан утгаар хэрэглэгдэхдээ ихэвчлэн өмнөө *ime* "бүү, битгий" гэсэн хориглох үгтэй нөхөцдөг. Жишээлбэл, манжийн "Gebungge saisai isabuha bithe (Эрдэмтэн сайчуулын хураасан бичиг)" хэмээх сургаалын зохиолд өгүүлбэр төгсгөх - *ra*, - *re*, - *ro* (- *gtun*, - *gtün*) нөхцөлтэй үг нийт 15 байгаагийн 13 нь өмнөө *ime* "бүү, битгий" гэсэн хориглох үг авчээ. Тэрчлэн манж хэлний *ime* хориглох сул үг нь ямагт II биед захирах - *ra*, - *re*, - *ro* нөхцөлөөр хэлбэржсэн үгтэй холбогдож байна. Иймд эл зохиолд буй "bitegey...-qu/kü" бүтэц бүхий 12 өгүүлэхүүн нь манж хэлний "ime... -ra/re/ro"-ийн орчуулга болох нь маргаангүй байна.

Үгийн хэрэглээ, найруулга өөрдсөн нь

Сурах бичигт чухам үгчилж буулгасан эх нь манжаар байжээ гэж таамаглахуйц ойлгомжгүй болсон үг өгүүлбэр цөөнгүй байна.

1. Манж хэлний *sabu*- хэмээх үйл үг нь 1. үзэгдэ-, 2. үзэ- гэсэн ацадмал утгатай. Үүнийг эс хайхарснаас дараах ойлгомжгүй өгүүлбэр бий болжээ.

ene ušar-a ämayi oγtu olju üjegdegsen ügey (1.18a)
bi tegün-i üjegdekü ügey (3.7a)

2. Манж хэлэнд өөрийн төлөөний үгийн утгыг бие гэдэг үгээс гадна аль нэгэн тийн ялгалын нөхцөлөөр хэлбэржсэн биеийн төлөөний үгийн тусламжтай илтгэдэг.

odo öber-tür biäγ daγudaqu šabi nar kedü buy (3.7a-b)
kedü ügey bolbaču mön nököd-tür aγsun abuju öber-tür neyilegül-ün öggümüy. (2.12b).
abaγay γayca änu beye-γi medekü baqan-a. Man-u bey-e-γi medekü ügey bolay. (2.3a).

Энд зүй нь эхний 2 өгүүлбэрийн *öber-tür* гэдгийг *tegün-dür* гэх байсан нь урд хойтох өгүүлбэрээсээ тодорхой байгаа юм. Зохиол дахь харилцан ярианаас үзвэл сүүлийн жишээн дэх "abaγay" нь сонсогч этгээд тул *önu beye*-ийг өөрийн бие гэвэл сая монгол өгүүлбэр болох билээ. Иймд, *tegün-dür*, *önu* зэргийг манж хэлний *inde*, *sini* зэрэг үгийн орчуулга гэж үзэхээс аргагүй санагдана.

Монгол хэлээрхи манж үг хэллэг

1. *ǎ egün-eǎe uruysi taniqu ülü taniquy-yi bitegey boduqu* (1.6a).

Өмнө дурдсанчлан энэ өгүүлбэрийн төгсгөл нь *boduɣtun* байх ёстой. Өгүүлбэрийн *egün-eǎe uruysi* гэдэг цагийн байц гишүүн нь *bitegey boduɣtun* гэдэг өгүүлэхүүнтэй холбогдохоос *taniqu, ülü taniqu* гэдэг үгтэй холбогдох учиргүй. Иймд *egün-eǎe uruysi* гэдэг хэллэг ирээдүй цагийн утгыг илтгэж байна. Монголчууд ирээдүй цагийн утгыг илэрхийлэхдээ "үүнээс хойш" гэж хэлэлцдэг бол манж нар *ereǎi Julesi* "үүнээс урагш" гэж бичсэн байх нь цөөнгүй тохиолддог.

2. *bi tusqayilan man-u biǎqan er-e keüken-iyer abur-a oduɣulba* (1.19b-20a).

Энд нуган, хөвүүн гэхийн оронд *er-e keüken* хэмээсэн нь манж хэлний "*haha jui*" гэдэг үгийн хуулбар орчуулга бололтой.

3. Манж хэлэнд одоо ба ирээдүй цагийн - *mbi* нөхцөлт үгийн дараа *qai* "болой" хэмээх туслах үг орох нь элбэг. Монгол хэлэнд ийм "- *muɣ bolay*" гэсэн нийлц үл тохиолдох ба "-*mbi qai*"-г даруй "-*qu/kü bolay*"-гаар монголчлоход сайхан таардаг. Гэтэл "**Ch'ophae mongǎ**"-д

-*ǎdamuɣ bolay* (1.5a, 2-10b)

-*jokimuɣ bolay* (1-10b)

-*ǎnümüɣ bolay* (2-8b)

-*soɣtumuɣ bolay* (2-10b)

гэх мэт төгсгөлтэй өгүүлбэр тохиолдож байгааг манжаас үгчлэн орчуулсантай холбон үзэж байна.

4. *-Abaɣay ǎ ali qosiyutay* (3.1a)

-*Nasu kedü bolba.*

-*Arban yisün nasu bolba.*

-*Yaɣun jiltay*

-*Luu-yin jiltay*

-*ǎnu degüw-yin nasu kedü*

-*Sayiqan jiryuɣan nasu boljuquy* (3.2a)

Монголчууд тэдэн нас хүрэх гэхээс тэдэн нас болох гэхчлэн хэлж бичдэггүй. Энэ харилцан яриа нь манжийн бичигт тэмдэглэгдсэн зүйл төдийгүй орчин үеийн Хар мөрөн мужийн манж нарын жил насаа хэлэлцэх үгстэй бүр адил байна. Иймэрхүү илэрхий "монгол хэлээрхи манж өгүүлбэр" эл сурах бичгийн харилцан яриа, текстэд олон бий.

Түүнчлэн бичвэрт арван хоёр толгой үсэг, дусал бинт, хэх хаха хэмээн гадна гэсэн манж соёлын холбоотой үгс гарч буйг бас бодууштай.

Жишээлэн дурдсан дээрх бүх тохиолдол төдийгүй, ерөөс эл зохиолын монгол бичвэрийг өгүүлбэрийнх нь гишүүдийн дэс дараа, бүтэц бүрэлдэхүүнийг алдагдуулалгүй манжаар үгчлэн буулгаж үзтэл, бүхэлдээ монгол хэлнийхээсээ илүү манж хэлний онцлог найруулгад нийцсэн эх гарч байна. Иймд, хэдий Ch'ophae нэрт зохиолын зөрчин ба манжтай

холбогдох талаар сурвалжийн мэдээ болон судлаачдын дурдсан зүйл өнөө хир байхгүй боловч, түүнээс үл эмээн Ch'orhae Mongō-д буй бичвэрийн анхдагч эх (юм уу ноорог) манжаар байсан бололтой гэж үзмээр байна.

Солонгосчууд зерчин, манж хэлнийхээс илүү монгол хэлний сургалтын эртний уламжлалтай, монгол нутагт монголчуудын дунд байж монгол хэл эзэмшсэн бичигтэн, багш нартай байсан боловч 18-р зууны үе болоход хэрэгцээ шаардлага, цэвэр уугуул хэлтэнтэй нь харилцах боломж зэргээс шалтгаалан манж хийгээд монгол хэлийг сурч эзэмших хир чинээ нь харилцан-харьцуулбаас Дайчин улсын эхэн ба түрүү үеийнхээс урвуу байдалтай болсон биз ээ. Уламжилсан хувилбарууд нь нэгэн цаг үед нэг хүн засаж хэвлүүлсэн боловч Mongō nogoltae Юань улсын үед бий болсны хувьд сонгодог монгол хэлний өмнөх үеийн онцлогийг хадгалж, манж нарын нөлөө давуу болсон үед зохиогдсон Ch'orhae Mongō-д манж хэлний нөлөө тусгал их байна.

18-р зууны үед солонгост манж хэл сайн мэдэх хүн цөөнгүй байсан бөгөөд зарим монгол хэл сурагсдад манж хэл дам гүүр болж байсан бололтой. Тиймээс, бидний авч үзэж буй сурах бичгийг анх зохион үйлдэхэд шууд монгол эхийг барилгүй манж хэлээрхи (бэлэн эсвэл зориуд зохион найруулсан) эхийг хэрэглэгдэхүүн болгож ашигласан байна. Ингэх нь монгол солонгос хадмал орчуулга хийхэд дөхөмтэй байсантай холбоотой болов уу. Гэхдээ, эл хадмал бичгийн хэвлүүлэгч Бан Хё-он (Pang Hyo-on) тэргүүтэн монгол хэлийг сайн сурсан бичгийн хүмүүс байсны дээр уг зохиолоо зориуд монгол хүмүүсээс асууж нягталж байсан гэдэг.

Үүнээс гадна, ерөөс энэ сурах бичгийн монгол хэл бол харьцангуй эрт манжид дагаж орон үе дамжин тэндээ суурьшсан, жинхэнэ манж найман хошууны дотор багтсан 235 овог монголчуудын манжижсан хэл аялгууны байдлыг харуулж буй гэж таамаглан үзэх өөр нэгэн бололцоо бий. Энэ нь цаашид нягтлан үзүүштэй сонирхолтой асуудал юм.

Ашигласан ном зохиол

1. "Ch'orhae mongō" 1790 оны барын хуулбар хэвлэл.
2. И Сон Гю. "Монгол хэлний гурван сурах бичигт гарч байгаа монгол хэлний онцлог" Монгол солонгосын хамтарсан эрдэм шинжилгээний хурал. УБ., 2001.03.24. 21-39 дүгээр тал.
3. И Сон Гю. Дундад зууны солонгос дахь монгол хэлний сурах бичгүүдийн тухай (гар бичмэл).
4. Ким Ки Сонь. XIII-XVIII зууны үед солонгост гарсан монгол хэлний 16 сурах бичгийн тойм. УБ., 1993. (гар бичмэл).
5. Го.Мижиддорж. Монгол манж бичгийн хэлний харьцаа. УБ., 1976
6. "Gebuingge saisai isabuha bidxe" Я.Шаарийбуу. Манж утга зохиолын дээж. УБ., 1999. 133-161 дүгээр тал.
7. Song Ki-joong. The Study of Foreign Languages in the Chosōn Dynasty (1392-1910). Korean studies dissertation series №1. Seoul. 2001.

차	차라	차라	차라	차라	차라
아차라	아차라	아차라	아차라	아차라	아차라
아차	차	차	차	차	차
아차라	차라	차라	차라	차라	차라
차	차	차	차	차	차
차	차	차	차	차	차

차	차라	차라	차라	차라	차라
아차라	아차라	아차라	아차라	아차라	아차라
아차	차	차	차	차	차
아차라	차라	차라	차라	차라	차라
차	차	차	차	차	차
차	차	차	차	차	차

"Ch'orphae monggo" зохиолын 1790 оны хэвлэлийн 176, 18а нүүр.